



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№133 /347/

2022.08.01

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ, ЯПОН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМТАРСАН “ЗАМ-2022” СУРГАЛТ, ДАДЛАГА ЭХЭЛЛЭЭ

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний хамтарсан “Зам-2022” сургалт, дадлага 12 дахь удаагаа зохион байгуулагдахад бэлэн боллоо.

Энэхүү хамтарсан сургалт, дадлага нь Монгол Улсын Батлан хамгаалах яам, Япон Улсын Батлан хамгаалах яам хоорондын байгуулсан хэлэлцээрээр “Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн салбарын чадавхыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд цэргийн инженерүүдийг зам барих аргад сурган дадлагажуулах, багшлах бүрэлдэхүүнийг бэлтгэх, мэдлэг ур чадварыг нь нэмэгдүүлэх, туршлага солилцох зорилгоор 2014 оноос хойш тасралтгүй хэрэгжиж байна.

“Зам-2022” хамтарсан сургалт, дадлагын нээлтийн ёслолд Монгол Улсын талаас Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал, Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого стратеги, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн хурандаа М.Батболд,



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн инженерийн дарга дэд хурандаа Г.Мөнхбат, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар, Япон Улсын талаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюки, Батлан хамгаалахын

атташе дэд хурандаа Ирики Ёохэй, Сургалтын багийн ахлагч хошууч Такаха Хироказү нараар ахлуулсан хоёр орны инженерийн цэргийн алба хаагчид оролцлоо.

Нээлтийн арга хэмжээнд бригадын генерал Ч.Цогтжаргал хэлсэн үгэндээ “Зам” хамтарсан сургалт,

дадлага нь хоёр улсын цэргийн хамтын ажиллагаанд чухал байр суурь эзэлдгийг онцлоод Монгол Улсын инженерийн цэргийн чадавхыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг цохон тэмдэглэв.

/Үргэлжлэл нь II нүүрт/

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.193.00	3.198.0
EUR 🇪🇺	3.263.0	3.280.0
CNY 🇨🇳	474.00	477.00
RUB 🇷🇺	48.50	49.50
JPY 🇯🇵	23.75	24.00
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.08.01 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Бие эрхтний хүч сайжирна.

Наран ургах, шингэх:

05.28-20.29

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Сансар


Суудал: Төмөр

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.



ОЮУТАН ЦЭРГҮҮД ТАНГАРГАА ӨРГӨЛӨӨ



шаардлага шалгуурыг бүрэн биелүүлдэг цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн албан хаагч, эх орны цэрэг боллоо. Цэргийн тангараг бол эх орондоо үзүүлж буй гүн хүндэтгэл юм” гэв.

Хоёр жил завсарласны дараа зохион байгуулагдсан энэ удаагийн сургалтад 52 их, дээд сургуулийн 452 оюутан цэргийн эрдэмд суралцав. Эдгээр оюутнууд нь энэхүү сургалтад хамрагдахын тулд голч дүн 3.4 болон түүнээс дээш байж, эрүүл мэндийн үзлэг, бие бялдрын шалгуур давсан бөгөөд эхний шатандаа “Цэргийн ерөнхий бэлтгэл” онолын сургалтыг МУИС, ШУТИС, ХҮИС, МУБИС-дад тус тус танхимаар хоёр сарын хугацаанд хамрагдсан бол “Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт”-аа ҮБХИС-ийн Шар хад дахь Сургалтын төвд хамрагдах, цэргийн албанд дасгах, мэргэжлийн бэлтгэл, цэргийн мэргэжил олгох гэсэн гурван үе шаттайгаар суралцав. Тодруулбал,

/Үргэлжлэл нь II нүүрт/

Монгол Улсын Засгийн газраас долоо дахь жилдээ зохион байгуулж буй “Оюутан цэрэг” сургалтын цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт өнгөрөгч Бямба гарагт /07.30/ өндөрлөж, оюутан цэргүүд тангаргаа өргөлөө. ҮБХИС-ийн Шархад дахь хээрийн Сургалтын төвд болсон оюутан цэргүүдийн тангараг өргөх ёслолд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ҮБХИС-ын захирал бригадын генерал П.Жаргалан, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Б.Ялалт, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Д.Дугаррагчаа болон Их дээд сургуулиудын удирдлага, холбогдох албан тушаалтнууд, оюутан

цэргүүдийн гэр бүлийнхэн оролцлоо. “Оюутан цэрэг” сургалт нь их, дээд сургуулийн оюутан залуусыг цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтад хамруулснаар өвөг дээдсийнхээ дайчин өв уламжлал, өнөөгийн цэрэг, армийн ололт амжилтаас суралцсан, эх оронч хүмүүжилтэй, оюунлаг, өндөр боловсролтой өв тэгш монгол хүнийг төлөвшүүлэх зорилготой юм.

ҮБХИС-ийн захирал П.Жаргалан оюутан цэргийн тангараг өргөх ёслолыг нээж хэлсэн үгэндээ “Иргэнийхээ журамт үүргийг биелүүлж байгаа оюутан цэргүүдэд баяр хүргэе. Та бүхэн цэргийн тангараг өргөснөөр эх орон дуудсан цагт эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу бэлэн байж, тавигдаж байгаа



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 582,373,933

Эдгэрсэн

Нийт: 552,651,454

Нас барсан

Нийт: 6,419,951

ОЮУТАН ЦЭРГҮҮД ТАНГАРГАА ӨРГӨЛӨӨ



Түрүүч нь I нүүрт/
“Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалт”-д хамрагдаж байгаа оюутнууд дөрвөн бүлэгт хуваагдан дадлага, сургалтад хамрагдсан юм. Сургалтыг эрчимжүүлсэн, вакуумжуулсан тусгай хөтөлбөрөөр өдөрт 10 цагийн багц хичээлээр явуулсан бөгөөд энэ хүрээнд цэргийн дүрэм,

жагсаалын бэлтгэл, тактик, галын бэлтгэл, цэргийн байр зүй, зенит, артиллерийн бэлтгэл, амьд гарах арга ухаан, анхны тусламж зэрэг 12 хичээлийг нийт 560 цагийн багтаамжтайгаар явуулсан юм. Эдгээр нь цэргүүдэд бие бялдар, сэтгэл зүйн тэсвэр хатуужил олгох, байлдаанд байлдагчийн үүргийг биелүүлэх, тасаг

тоотын жигдрэлтийг хангах, хүн нэг бүрд цэргийн бага мэргэжил эзэмшүүлэхэд тус сургалт чиглэгджээ. “Оюутан цэрэг-2022” сургалт явагдаж байх хугацаанд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын

генерал Ж.Болдбаатар болон их дээд сургуулийн удирдлага, холбогдох албан тушаалтнууд хүрэлцэн ирж сургалтын үйл явцтай танилцсан юм. Хэдийгээр 12 сарын хугацаанд цэргийн алба хаах хуультай боловч олон мянган оюутан залуусаас шигшигдэж ирсэн залуус богино хугацааны эрчимжсэн сургалтад

хамрагдаж, ачаалал даах, цэргийн мэргэжил эзэмших бүрэн боломж олгодог тус сургалт ийнхүү 7 дахь удаагаа амжилттай зохион байгуулагдлаа. Сонирхуулахад “Оюутан-цэрэг”-2022 хөтөлбөр энэ жил анх удаа “E-Mongolia” цахим платформоор бүртгэл явуулсан ба нийт 1472 оюутан бүртгүүлжээ.

Эдгээр оюутнаас голч оноогоор жагсаан, эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалтад хамруулсан бөгөөд сонгон шалгаруулалтад 479 оюутан тэнцсэн ба 452 оюутан цэргийн хөтөлбөрт бүрэн хамрагдаж цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн алба хаагчид болж албаа дуусгалаа.

Цахим шууданд

МОНГОЛ, ЯПОН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМТАРСАН “ЗАМ-2022” СУРГАЛТ, ДАДЛАГА ЭХЭЛЛЭЭ

Түрүүч нь I нүүрт/
Мөн Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-д инженерийн цэргийн рот оролцуулах бэлтгэл ажилд энэхүү хамтарсан сургалт том дэмжлэг үзүүлж буйг ч онцлолоо.

Харин Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюки “Монгол Улсын инженерийн цэргүүдийн суралцах чадвар маш өндөр. Өмнөх жилүүдэд япон сургагч багш нарын заавар, зөвлөмжөөр сургалт явагддаг байсан бол энэ

жилээс монгол цэргүүд өөрсдөө бие даан удирдан явуулна. Манай сургагч багш нар зөвхөн зөвлөх үүрэгтэй оролцоно. Энэ нь монгол цэргүүдийг суралцах чадвар сайн, гүйцэтгэл өндөр, дасан зохицох онцгой авьяастай гэдгийг батлан харуулж байгаа хэрэг юм” гэж онцлоод сургалтын үйл ажиллагаанд өндөр амжилт хүссэн юм.

Энэ удаагийн сургалт нь 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 20 гаруй хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийг түшиглэн авто замын далан, ус зайлуулах байгууламж барих бөгөөд дадлагаар АНУ-ын Батлан хамгаалах яамнаас тусламжаар нийлүүлсэн инженерийн зарим техник, тоног төхөөрөмжийг ажиллагаанд оруулж, ашиглах юм.

Монгол Улс, Япон Улсын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн салбарын офицер, ахлагч нарын авто зам, авто замын ус зайлуулах байгууламжийн зураг төслийг боловсруулах, барих чадвар дадлагыг нэмэгдүүлэх, мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор ийнхүү 8 дахь жилдээ 12 дахь сургалт, дадлагыг хамтран зохион байгуулж эхэллээ.

Арга хэмжээний төгсгөлд Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюки Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалтай танилцсан юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОР

27 ТҮРҮҮЧ, БАЙЛДАГЧ ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБАНД УЛИРАХ ХҮСЭЛТЭЭ ӨГЛӨӨ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Тус ангиас хугацаат цэргийн алба хааж байгаа түрүүч, байлдагч нарын эцэг эх, ар гэрийн төлөөллийг урьж “Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба” сурталчилгааны арга хэмжээг 7 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа.

Тус анги 2021-2022 оны сургуулийн жилд иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдаар бүрдүүлсэн хөгжмийн салааны тайлан тоглолтыг эцэг, эхчүүдэд хүргэсэн бол энэ удаа цэргийн гэрээт албыг сурталчлах ажлаар үргэлжлүүлсэн юм.

Сурталчлах өдөрлөгөөр

ангийн захирагчийн нэгдүгээр орлогч дарга, штабын дарга, дэд хурандаа Ү.Уянгасайхан эцэг эхчүүдэд цэргийн гэрээт алба хаах эрх зүйн зохицуулалт, нийгэм хамгаалал, цалин хөлс, эдлэх боломжуудын талаар мэдээлэл хүргэж, Зэвсэгт хүчний өнөөгийн хөгжлийн талаар танилцуулга хийсэн юм. Ялангуяа “Цэргийн гэрээт алба хаах журам”-д заасанчлан тэргүүний цэргийн гэрээт алба хаагчид их, дээд сургууль, дотоод сургалт дамжаанд суралцаж, мэргэжил эзэмших, энхийг сахиулах ажиллагаа, бүтээн байгуулалтын ажилд оролцох боломж байдгийг онцлоод байнгын бүрэлдэхүүн шиг

ажлын найман цагаар ажилладгийг дуулгаж, эцэг эхчүүдийн сонирхсон асуултад харуулсан юм.

Энэхүү сурталчилгааны ажлын үр дүнд 27 хугацаат цэргийн алба хаагч цэргийн гэрээт албанд элсэх хүсэлт гаргасан бөгөөд тэдний эцэг, эхчүүдтэй тусгайлан уулзалт зохион байгуулан, алба хаах гэрээний нөхцөлийг танилцуулж, мэдээлэл солилцов. Эцэг, эхчүүдийн зүгээс хугацаат цэргийн албаа үлгэр жишээчээр хааж байгаа түрүүч, байлдагч нарыг цэргийн гэрээт алба, ахлагчийн албандаа сонгон шалгаруулж элсүүлэх ажлыг эрчимжүүлэхийг захиж байсан юм.

З.ӨСӨХБАЯР

